



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 22 өдөр

Дугаар А/06

Бат-Өлзий сум

Хөрөнгө зарцуулах тухай

Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “2024 оны төсөв батлах тухай” 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 18/03 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улаанбаатар хотоос хөнгөлөлттэй үнээр ирж буй 25 тн хивэг тээвэрлэлтийн зардалд 2,500,000 (хоёр сая таван зуун мянга) төгрөгийг зарцуулсугай.

2. Зардалд шаардагдах 2,500,000 (хоёр сая таван зуун мянга) төгрөгийг Засаг даргын Тамгын газрын Эрсдэлээс хамгаалах сангаас зарцуулахыг сумын Төсвийн ерөнхий нягтлан бодогч (О.Отгонтуяа)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

С.АМГАЛАН

